



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/105/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Авас. 02.24 № 253
танай Авас. 01.24-ны № 25 -т

ДОРНОД АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Г.ГАРАМХИШИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилтны цалинг 14,261.5 мянган төгрөгөөр илүү, 2,142.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, малын нас дэвшилтийг хийгээгүй, нийт хөрөнгийн жагсаалтад үнийн дүн тусгаагүй, гарын үсэг зурж тооллогыг баталгаажуулаагүй 270,653.8 мянган төгрөгийн тооллогыг хангалтгүй хийсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон борон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн

011022158

байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 14 зорилт, 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Цаг уур, орчны шинжилгээний газраас 87.4 хувьтай үнэлсэн байна.

Байгууллагын дарга нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, тушаал гарган ажлын байран дээр байхгүй хүнд 5,618.1 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасан, санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажиллаагүй байна. Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Төсвийн захирагч, энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтан үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно" гэж заасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	247,316,563.55	272,352,246.46
33	АВЛАГА	19,108,843.66	1,698,365.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,108,843.66	1,698,365.42
335	Бусад авлага	19,108,843.66	1,698,365.42
3351	Байгууллагаас авах авлага	-	1,698,365.42
35	БАРАА МАТЕРИАЛ	228,207,719.89	270,653,881.04
351	Түүхий эд материал	152,278,016.43	175,853,192.58
35110	Тусгай зориулалттай материал	152,278,016.43	175,853,192.58
354	Хангамжийн материал	44,079,703.46	73,190,688.46
35410	Бичиг хэргийн материал	95,000.00	325,000.00
35420	Аж ахуйн материал	5,010,718.00	5,526,018.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,610,200.00	9,970,385.00
35450	Барилгын засварын материал	-	62,500.00
35470	Бусад хангамжийн материал	37,363,785.46	57,306,785.46
35600	Мал амьтад	31,850,000.00	21,610,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	786,736,021.18	1,143,968,550.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	786,736,021.18	1,143,968,550.05
392	Биет хөрөнгө	350,646,021.18	606,378,550.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	251,325,640.00	299,001,879.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(68,631,000.58)	(82,857,506.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,887,573.76	69,887,573.76
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,282,046.76)	(21,261,885.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	503,710,740.61	754,870,935.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(395,234,856.71)	(418,292,134.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,328,943.17	19,328,943.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,483,972.31)	(14,324,255.07)
39217	Ном	25,000.00	25,000.00
393	Биет бус хөрөнгө	436,090,000.00	537,590,000.00
39301	Программ хангамж	-	1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	436,090,000.00	536,090,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,034,052,584.73	1,416,320,796.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,120,650.54	2,502,660.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,120,650.54	2,502,660.63
413	Өглөг	1,120,650.54	2,502,660.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,120,650.54	2,164,552.63
4136	Бусад өглөг	-	338,108.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	338,108.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,032,931,934.19	1,413,818,135.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,032,931,934.19	1,413,818,135.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	848,771,602.64	948,771,602.64
51101	Өмч: - төрийн	848,771,602.64	948,771,602.64
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	848,771,602.64	948,771,602.64
512	Хуримтлагдсан үр дүн	184,160,331.55	465,046,533.24
51210	Өмнөх үеийн үр дүн	(137,041,897.87)	(156,150,741.53)
51220	Тайлант үеийн үр дүн	-	299,995,045.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	321,202,229.42	321,202,229.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,034,052,584.73	1,416,320,796.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,741,040,142.63	3,089,357,761.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,867,642.63	234,060,062.17
120	Нийтлэг татварын бус орлого	41,867,642.63	234,060,062.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,867,642.63	234,060,062.17
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000.00	208,900.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	47,676,239.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	41,737,642.63	186,174,923.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,699,172,500.00	2,855,297,699.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,671,997,200.00	2,787,106,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,671,997,200.00	2,787,106,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,175,300.00	68,191,599.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	42,762,149.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,175,300.00	11,429,450.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,841,859,217.70	2,789,362,715.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,841,859,217.70	2,789,362,715.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,821,807,413.58	2,747,843,815.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,427,102,773.37	2,309,454,647.63
210101	Үндсэн цалин	883,054,673.37	1,197,430,447.61
210102	Нэмэгдэл	304,331,600.00	670,465,200.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	122,000,000.00	293,601,700.00
210104	Урамшуулал	117,716,500.00	147,957,300.00
210104	Гэрээт ажлын цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,094,150.54	315,351,497.04
210201	Тэтгэврийн даатгал	122,822,550.54	225,038,177.92
210202	Тэтгэмжийн даатгал	14,317,900.00	21,978,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,454,300.00	13,390,519.12
210204	Ажилгүйдлийн даатгал	2,863,600.00	10,989,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,635,800.00	43,955,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,861,682.53	18,395,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,270,900.00	3,896,614.32
210302	Түлш, халаалт	12,114,800.00	11,977,300.00
210303	Цэвэр, бохир ус	5,475,982.53	2,521,285.68
2104	Хангамж, бараа материалын зардал	137,697,224.20	23,146,115.00
210401	Бичиг хэрэг	1,947,041.00	899,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,844,680.00	8,434,415.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,912,522.35	1,439,698.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,400.00	372,501.60

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	122,135,580.85	12,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,833,100.00	3,991,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	274,800.00	601,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		123,400.00
210604	Урсгал засвар	1,558,300.00	3,266,300.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	4,110,200.00
210702	Дотоод албан томилолт		4,110,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,844,621.04	9,490,749.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,386,200.00	8,916,849.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,280.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,100.00	27,600.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	440,000.00	78,900.00
210807	Газрын төлбөр	908,041.04	417,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,100,361.90	63,904,007.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,731,596.96	20,800,102.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,368,764.94	43,103,905.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,051,804.12	41,518,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,051,700.00	41,440,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,051,700.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	41,440,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	104.12	78,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-100,819,075.07	299,995,045.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-100,819,075.07	299,995,045.35
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-100,819,075.07	299,995,045.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-100,819,075.07	299,995,045.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,699,302,500.00	2,855,506,599.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	130,000.00	208,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	130,000.00	208,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	130,000.00	208,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	130,000.00	208,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,699,172,500.00	2,855,297,699.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,671,997,200.00	2,787,106,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,175,300.00	68,191,599.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	42,762,149.00

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,429,450.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	1,699,302,500.00	2,749,524,299.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,699,302,500.00	2,749,524,299.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,699,302,500.00	2,749,524,299.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,679,250,695.88	2,708,005,399.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,431,788,700.00	2,309,094,200.00
210101	Үндсэн цалин	887,740,600.00	1,197,070,000.00
210102	Нэмэгдэл	304,331,600.00	670,465,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	122,000,000.00	293,601,700.00
210103	Урамшуулал	117,716,500.00	147,957,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,973,500.00	316,028,300.00
210201	Тэтгэврийн даатгал	121,701,900.00	228,116,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,317,900.00	21,978,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,454,300.00	10,988,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,863,600.00	10,989,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,635,800.00	43,955,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,861,682.53	18,395,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,270,900.00	3,896,614.32
210302	Түлш, халаалт	12,114,800.00	11,977,300.00
210303	Цэвэр, бохир ус	5,475,982.53	2,521,285.68
2104	Хангамж, бараа материалын зардал	14,850,402.35	11,132,415.00
210401	Бичиг хэрэг	708,400.00	899,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,253,680.00	8,434,415.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,042,522.35	1,439,698.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	845,800.00	358,801.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,863,690.00	9,996,400.00
210601	Багаж техник хэрэгсэл	387,300.00	6,091,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,770,790.00	123,400.00
210604	Урсгал засвар	11,705,600.00	3,781,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,273,500.00	4,110,200.00
210702	Дотоод албан томилолт	3,273,500.00	4,110,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,844,621.04	29,433,749.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,386,200.00	28,766,849.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,280.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	28,100.00	27,600.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	440,000.00	171,900.00
210807	Газрын төлбөр	908,041.04	417,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,794,599.96	9,814,935.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,794,599.96	9,814,935.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,051,804.12	41,518,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,051,700.00	41,440,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	41,440,000.00

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,051,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	104.12	78,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	105,982,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	105,982,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	105,982,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	105,982,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(105,982,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	848,771,602.64	321,202,229.42	(137,041,897.87)	1,032,931,934.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,000,000.00	-	(19,108,843.66)	80,891,156.34
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	948,771,602.64	321,202,229.42	(156,150,741.53)	1,113,823,090.53
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	299,995,045.35	299,995,045.35
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	948,771,602.64	321,202,229.42	143,844,303.82	1,413,818,135.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	2,781,554,500.00	2,855,427,699.00	(73,873,199.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000.00	208,900.00	(78,900.00)
12	Татварын бус орлого	130,000.00	208,900.00	(78,900.00)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,781,554,500.00	2,855,427,699.00	(73,873,199.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,781,554,500.00	2,813,987,699.00	(32,433,199.00)

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,781,554,500.00	2,813,987,699.00	(32,433,199.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,781,554,500.00	2,813,987,699.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,781,554,500.00	2,813,987,699.00	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,309,094,200.00	2,309,094,200.00	-
210101	Үндсэн цалин	1,197,070,000.00	1,197,070,000.00	-
210102	Нэмэгдэл	670,465,200.00	670,465,200.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	293,601,700.00	293,601,700.00	-
210104	Урамшуулал	147,957,300.00	147,957,300.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,028,300.00	316,028,300.00	-
210201	Тэтгэврийн даатгал	228,116,600.00	228,116,600.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	21,978,000.00	21,978,000.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,988,900.00	10,988,900.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	10,989,000.00	10,989,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	43,955,800.00	43,955,800.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,395,200.00	18,395,200.00	-
210301	Гэрэл, цахилгаан	3,709,100.00	3,896,614.32	(187,514.32)
210302	Түлш, халаалт	11,977,300.00	11,977,300.00	-
210303	Цэвэр, бохир ус	2,708,800.00	2,521,285.68	187,514.32
2104	Хангамж, бараа материалын зардал	6,956,600.00	11,132,415.00	(4,175,815.00)
210401	Бичиг хэрэг	253,500.00	899,500.00	(646,000.00)
210402	Тээвэр, шатахуун	4,924,600.00	8,434,415.00	(3,509,815.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,417,700.00	1,439,698.40	(21,998.40)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360,800.00	358,801.60	1,998.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	96,776,500.00	105,978,700.00	(9,202,200.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл	96,379,900.00	102,073,700.00	(5,693,800.00)
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	123,400.00	123,400.00	-
210604	Урсгал засвар	273,200.00	3,781,600.00	(3,508,400.00)
2107	Томилолт, зочны зардал	1,980,200.00	4,110,200.00	(2,130,000.00)
210702	Дотоод албан томилолт	1,980,200.00	4,110,200.00	(2,130,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,728,300.00	39,433,749.00	(8,705,449.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,061,400.00	38,766,849.00	(8,705,449.00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	27,600.00	27,600.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	171,900.00	171,900.00	-
210807	Газрын төлбөр	417,400.00	417,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,595,200.00	9,814,935.00	(8,219,735.00)

Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,595,200.00	9,814,935.00	(8,219,735.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		41,440,000.00	(41,440,000.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг		41,440,000.00	(41,440,000.00)
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	41,440,000.00	(41,440,000.00)
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	104.12	78,900.00	(78,900.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,781,554,500.00	2,855,427,699.00	(73,873,199.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,781,424,500.00	2,787,027,200.00	(73,794,299.00)
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,781,424,500.00	2,787,027,200.00	(5,602,700.00)
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,000,000.00	(14,000,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	-	42,762,149.00	(42,762,149.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,429,450.00	(11,429,450.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	74	74	
620001	Удирдах ажилтан	4	4	100
620002	Гүйцэтгэх ажилтан	69	69	100
620003	Үйлчлэх ажилтан	1	1	100

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 146.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 146.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй 146.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэснийг үндсэн хөрөнгөд бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 280.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 273.3 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7.5 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмжийг өглөө.

2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч 100 хувь, нярав 100 хувиар тооцоолон 2.7 сая төгрөг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Эд хариуцагчийн тооллого хийсэн боловч нэг бүрийн үнэ ихэнх хөрөнгөд тусгаагүй, мал тооллогыг зөрүүтэй бүртгэлд тусгасан, малын нас дэвшилтийг хийгээгүй, нийт хөрөнгийн жагсаалтыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй 270.6 сая төгрөгийн тооллогыг хангалтгүй хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Байгууллагын дарга нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, тушаал гарган ажлын байран дээр байхгүй хүнд цалингийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-т "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасан, санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажиллаагүй байна. Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Төсвийн захирагч, энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтан үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн шийдвэрийн хэрэгжилтэй холбоотой

Илрүүлэлт 1: НДШ-ийн тайланд 4 ажилтны цалинг нийт 14,261,589.13 төгрөгөөр илүү тайлагнаж байгууллагаас НДШ-ийг илүү 1.6 сая төгрөг төлсөн. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд авлагаар тусгаж, НДШ-ийн тайланд залруулга хийх.

Илрүүлэлт 2: НДШ-ийн тайланд 3 ажилтны цалинг 2.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж, НДШ-ийн тайланд залруулга хийх.

Илрүүлэлт 3: НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн код зөрүүтэйгээс байгууллагаас төлөх шимтгэлийг 3.7 сая төгрөгөөр илүү төлсөн. Энэ нь УСНББОУС 01, нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн кодыг тулган ижил болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй 146.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэснийг үндсэн хөрөнгөд бүртгэж залруулав.	1	146,677.9					1	146,677.9				
Дүн	1	146,677.9					1	146,677.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг олгосон	1	2,681.0			1	2,681.0						
Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн	1	270,653.9			1	270,653.9						
Байгууллагын дарга нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, тушаал гарган ажлын байран дээр байхгүй хүнд цалингийн зардал гаргасан	1	-							1	-		
НДШ-ийн тайланд 4 ажилтны цалинг нийт илүү тайлагнаж байгууллагаас НДШ-ийг илүү сая төгрөг төлсөн	1	1,652.5					1	1,652.5				
НДШ-ийн тайланд 3 ажилтны цалинг дутуу тайлагнасан.	1	2,142.2					1	2,142.2				
НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн код зөрүүтэйгээс байгууллагаас төлөх шимтгэлийг илүү төлсөн	1	3,715.5					1	3,715.5				
Дүн	6	280,845.2			2	273,334.9	3	7,510.3	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 4 мэдээлэл хоцроон мэдээлсэн байна.	1	2,843,330.8			1	2,843,330.8		
Нийт дүн	1	2,843,330.8			1	2,843,330.8		



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 186/1946/5793
АВА - 2025/2057/НА - СТА - ТУУС

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 270,653,881.04 төгрөгийн бараа материал, эд хариуцагчийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, малын нас дэвшилтийн тооллого хийж тайлан бэлтгээгүй, нийт хөрөнгийн жагсаалтыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, анхан шатны баримт шаардлага хангахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно”, 2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2 дох “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эд материал, үнэ бүхий зүйлийн тооллогыг хууль тогтоомжинд заасан хугацаанд журмын дагуу хийж үлдэгдлийг тулган баталгаажуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040227

2. Хууль тогтоомж, холбогдох шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Г.Гарамхишиг, нягтлан бодогч Д.Баттуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 198/19925799
ДДА-2025/1057 НА-СТА-ТМЦ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч, нярав нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,681,000.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040225

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Г.Гарамхишиг, нягтлан бодогч Д.Баттуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 137/19128799
АВА-2025/1057 НА-СТА-ТМБ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Ус уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 18 гүйлгээ, худалдан авалтын 3 гүйлгээний 2,843,330,850.00 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 1.2-т “Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч (цаашид “байгууллага” гэх) нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж мэдээллийг тогтмол тавих, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040221

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Ус уаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Г.Гарамхишиг, нягтлан бодогч Д.Баттуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

